

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчист Монгол ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/70/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас:323266 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас:323266 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас:323266 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	17
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	17
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	17
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИСТ МОНГОЛ ТӨХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.АМАРТҮВШИН  
ТАНАА

2026.03.16 № 659  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчист Монгол ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 1,810.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авсан 143.0 сая төгрөг, цалингийн өглөг 42.9 сая төгрөг, татварын өр 6.4 сая төгрөг, санхүүгийн тайланд 192.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүй;
- Батлагдсан орон тоонд хүрч ажиллаагүйгээс агуулахын үлдэгдэлд 78.2 сая төгрөгийн хөрөнгөтэй, худалдан авалтыг бодитой хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөөгүй;
- Менежментийн үйлчилгээг үзүүлж буй нэг байгууллагаас авах 1,112.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгах эсэхийг эцэслэн шийдвэрлээгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй;
- Компанийн балансад бүртгэлтэй 358.9 сая төгрөгийн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын үр дүн, тайланд комиссын гишүүд гарын үсэг зурж

баталгаажуулаагүй, ашиглалтад тавьж олгоогүй хөрөнгөд 3.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан;

- Бараа материалыг зарцуулалтад тавьж олгохдоо зохих зөвшөөрөл авдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 15.7 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 286 дугаартай “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.6 дахь заалтыг өөрчлөн найруулж, эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн нийт хувьцааны 34 хувийн төлөөллийг “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хэрэгжүүлэхээр тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрчист Монгол ТӨХХК нь компанийн дүрэмд заасны дагуу зээл, хөрөнгө оруулалт, хөрөнгийн өгөөж, менежментийн төлбөр болон бусад эх үүсвэрээс санхүүжихээр тусгагдсан байна. Тайлант онд үйл ажиллагааны зардалд 4,493.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 224.6 сая төгрөг тус тус зарцуулах эх үүсвэрийг өөрийн харьяа 45 байгууллагаас 28 байгууллагатай байгуулсан менежментийн гэрээгээр 3,455.4 сая төгрөг, бусад орлогоос 2.9 сая төгрөг, арилжааны банкнаас авсан зээлээр 1,280.0 сая төгрөг, нийт 4,738.3 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Нийт орлого 3,356.9 сая төгрөг, нийт зардлыг 4,206.8 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч 849.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь шалгагдагч байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	20,216,603.07
1.1.2	Дансны авлага	-	231,800,300.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	-	13,695,630.36
1.1.4	Бусад авлага	-	3,038,390.00
1.1.6	Бараа материал	-	15,095,952.91
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	-	28,424,404.58
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>312,271,280.92</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	347,646,212.12
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	-	<b>347,646,212.12</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	<b>659,917,493.04</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	142,952,080.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	42,921,164.59
2.1.1.3	Татварын өр	-	6,413,944.32
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	1,280,000,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	-	11,477,589.04
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	<b>1,483,764,777.95</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	-	<b>1,483,764,777.95</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	-	1,000,000.00
2.3.2	- хувийн	-	
2.3.3	- Хувьцаат	-	
2.3.4	Халаасны хувьцаа	-	
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	25,000,000.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	(849,847,284.91)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	-	<b>(823,847,284.91)</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	-	<b>659,917,493.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	-	<b>3,354,224,970.01</b>
<b>2</b>	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	-	<b>3,354,224,970.01</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	2,718,939.33
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	4,079,978,287.40
11	Санхүүгийн зардал	-	126,812,906.85
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	-	<b>(849,847,284.91)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	<b>(849,847,284.91)</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал</b>	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	-	<b>(849,847,284.91)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
<b>27</b>	<b>Орлогын нийт дүн</b>	-	<b>(849,847,284.91)</b>
<b>28</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээ	Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	<b>(849,847,284.91)</b>	<b>(849,847,284.91)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000.00	-	-	-	-	-	-	1,000,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	25,000,000.00	-	-	-	25,000,000.00
2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<b>1,000,000.00</b>	-	-	<b>25,000,000.00</b>	-	-	<b>(849,847,284.91)</b>	<b>(823,847,284.91)</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>3,456,811,032.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,455,427,167.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		525,000.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		858,865.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>		<b>4,493,555,229.93</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн		2,785,726,993.32
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		797,500,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		35,191,047.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		13,734,302.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		2,701,139.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		112,196,317.81
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		615,710,841.03
1.2.9	Бусад мөнгөн зарлага		130,794,588.88
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(1,036,744,197.93)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>1,520,801.00</b>
2.2.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		1,520,801.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>224,560,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		224,560,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(223,039,199.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>4,565,060,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		4,565,060,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>3,285,060,000.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		3,285,060,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>1,280,000,000.00</b>
3.4	Валютын ханшийн зөрүү		-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>20,216,603.07</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>20,216,603.07</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>		-	<b>4,861,299,048.44</b>	<b>3,356,943,909.34</b>	<b>3,356,943,909.34</b>	-	<b>(1,504,355,139.10)</b>	<b>69.1</b>
1	Менежментийн үйлчилгээ	-	4,861,299,048.4	3,354,224,970.0	3,354,224,970.01	-	(1,507,074,078.43)	69.0
	Бусад	-	-	2,718,939.3	2,718,939.33	-	2,718,939.33	-
2	<b>Нийт орлого</b>	-	<b>4,861,299,048.44</b>	<b>3,356,943,909.34</b>	<b>3,356,943,909.34</b>	-	<b>(1,504,355,139.10)</b>	<b>69.1</b>
3	<b>Нийт зардал</b>	-	<b>4,458,806,274.85</b>	<b>4,206,791,194.25</b>	<b>4,206,791,194.25</b>	-	<b>(252,015,080.60)</b>	<b>94.3</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	-	1,021,148,970.23	983,050,188.40	-	-	(38,098,781.83)	96.3
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	-	<b>402,492,773.59</b>	<b>(849,847,284.91)</b>	-	-	<b>(1,252,340,058.50)</b>	<b>(211.1)</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	-	-	-	-	-	-	-
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	-	<b>1,684,159,358.72</b>	<b>1,413,210,841.03</b>	-	-	<b>(270,948,517.69)</b>	<b>83.9</b>
	а/ Орлогын татварт	-	40,249,277.40	-	-	-	(40,249,277.40)	-
	б/ НӨТ	-	485,910,294.56	301,675,626.82	-	-	(184,234,667.74)	62.1
	в/ НДШ	-	831,955,744.56	797,500,000.00	-	-	(34,455,744.56)	95.9
	г/ Хүн амын орлогын татвар	-	326,044,042.20	314,035,214.21	-	-	(12,008,827.99)	96.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	-	-	-	-	-	-
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	-	-	-	-	-	-	-
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	-	-	-	-	-	-	-
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	-	69	62	-	-	(7.00)	89.9
9	Нийт цалингийн сан	-	3,644,881,160.20	3,495,987,956.80	-	-	(148,893,203.40)	95.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	-	5,869,373.85	5,836,373.88	5,836,373.88	-	(32,999.96)	99.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	-	0.92	1.25	1.25	-	0.34	136.6
12	Хөрөнгө оруулалт	-	401,853,125.00	333,863,636.40	333,863,636.40	-	(67,989,488.60)	83.1
13	<b>Нийт авлага</b>	-	-	<b>248,534,320.36</b>	<b>248,534,320.36</b>	-	<b>248,534,320.36</b>	-
	Үүнээс: Найдваргүй	-	-	-	-	-	-	-
14	<b>Нийт өглөг</b>	-	-	<b>1,483,764,777.95</b>	<b>1,483,764,777.95</b>	-	<b>1,483,764,777.95</b>	-
	Богино хугацаат өр төлбөр	-	-	1,483,764,777.95	1,483,764,777.95	-	1,483,764,777.95	-
	Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-	-

## 2.6 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалтын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тавилга	98,841,200.00	79,081,818.18	(19,759,381.82)	80.0
2	Компьютер	240,758,000.00	204,145,454.55	(36,612,545.45)	84.8
3	Техник хэрэгсэл	62,253,925.00	50,636,363.64	(11,617,561.36)	81.3
	<b>Нийт</b>	<b>401,853,125.00</b>	<b>333,863,636.36</b>	<b>(67,989,488.64)</b>	<b>83.1</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолоор “Эрчист Монгол” ТӨХК-ийг үүсгэн байгуулжээ. “Эрчист Монгол” ТӨХК нь эрхэм зорилгоо төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, санхүүгийн сахилга бат, ил тод байдал, тогтвортой өсөлтийг дэмжих замаар зах зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж Монгол Улсын эдийн засагт бодитой хувь нэмэр оруулна гэж тодорхойлжээ.

Тус компанийн дүрэмд зааснаар харьяа компаниудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоох, бизнесийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөө, уялдаа зохицуулалтаар хангах болон санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр менежментийн үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах үндсэн үйл ажиллагааг явуулахаар тусгагдсан байна. Үүнд:

- Хүний нөөц, санхүү, маркетинг, үнэлгээ мониторинг зэрэг давхардсан чиг үүргүүдэд дүн шинжилгээ хийж, дундын үйлчилгээнд нэгтгэх;
- Захиргааны зардлыг бууруулах;
- Нэгдсэн стандарт, хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох;
- Нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Санхүүгийн тайлангийн дүн шинжилгээ, үр ашгийн тооцоо гаргах;
- Харьяа компаниудын мэдээллийг нэгтгэн өгөгдлийн сан бүрдүүлэх зэрэгт чиглэж байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани” статустай, өмчийн 100 хувийг эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газар, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 137 дугаартай “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн гадаад зээллэгийн хүрээнд үүссэн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, төлүүлэх ажлыг зохион байгуулах, 06 дугаар сарын 04-ний өдрийн 286 дугаар тогтоолоор эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн нийт хувьцааны 34 хувийн төлөөллийг “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хэрэгжүүлэхээр тусгасан байна.

“Эрчист Монгол” ТӨХК нь 2025 оны хугацаанд харьяа компаниудын санхүүгийн тайланд иж бүрэн шинжилгээ хийж, төсөв, санхүүгийн шинжилгээний моделийг боловсруулж, тус моделийн тусламжтайгаар эрчим хүчний салбарын 27 компани, хувьцаа эзэмших эрх бүрэн шилжсэн 6 компанийн санхүүгийн тайланд нарийвчилсан үнэлгээ хийж, үр ашгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Засгийн газарт танилцуулж, тэмдэглэлээр холбогдох үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан байна. Тухайлбал:

- “Монголын төмөр зам” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХК, “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн захиргаа, удирдлагын зардлыг оновчтой болгох, шаардлагагүй орон тоог бууруулах чиглэлээр хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, дүгнэлт гаргаж, 100 хоногийн төлөвлөгөөнд тусган Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулан, салбарын яамдуудтай хамтран хэрэгжүүлсэн;
- “МИАТ” ТӨХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг олон нийтэд санал болгон, стратегийн хөрөнгө оруулагч татах бэлтгэл ажлын хүрээнд тус компанийн зах зээлийн үнэлгээг хийж, IPO гаргах төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Засгийн

газарт хүргүүлж, хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн танилцуулсан;

- Эрчим хүчний салбарын компаниудын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд нэгтгэх, нийлүүлэх, хувьчлах, ТУЗ-ийн тоог цөөлөх (26-аас 14 болгох) замаар үйл ажиллагааны зардлыг 50 хүртэл хувь бууруулах, худалдан авах ажиллагаанд хяналт тавих, мөн 2026 оны зорилтот түвшнийг тодорхойлох чиглэлээр Эрчим хүчний яамтай хамтарсан ажлын хэсгүүдэд орсон.

“Эрчист Монгол” ТӨХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас гүйцэтгэлийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тухайлбал: Цаг бүртгэлийн систем байхгүйгээс цалинтай чөлөө, илүү цагийн бүртгэлийг үнэн зөв гаргасан эсэх эргэлзээтэй, бараа материалыг зарцуулалтад, үндсэн хөрөнгийг ашиглалтад тавьж олгох үед удирдлага, ерөнхий нягтлан бодогч анхан шатны баримтад цохолт хийдэггүй, дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байх эрсдэлтэй байна.

Тус байгууллага тайлант онд дотоод аудитын нэгж бүтэцгүй ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Эрчист Монгол” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Эрчист Монгол” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 659.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	20,216,603.07	20,216,603.07
Авлага	-	248,534,320.36	248,534,320.36
Урьдчилж төлсөн тооцоо	-	28,424,404.58	28,424,404.58
Бараа материал	-	15,095,952.91	15,095,952.91
Үндсэн хөрөнгө	-	347,646,212.12	347,646,212.12
<b>Нийт хөрөнгө</b>	-	<b>659,917,493.04</b>	<b>659,917,493.04</b>
Өр төлбөр	-	1,483,764,777.95	1,483,764,777.95
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	1,000,000.00	1,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		25,000,000.00	25,000,000.00
Хуримтлагдсан ашиг		(849,847,284.91)	(849,847,284.91)

<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>-</b>	<b>659,917,493.04</b>	<b>659,917,493.04</b>
--	----------	-----------------------	-----------------------

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, ашиг, алдагдлын дансдууд байна.

- Авлага дансны 248.5 сая төгрөгийн үлдэгдэл нь менежментийн үйлчилгээний гэрээ байгуулсан 5 хуулийн этгээдээс авах авлага 231.8 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.7 сая төгрөг, НӨАТ-ын авлага 13.0 сая төгрөг, ажилчид болон холбоотой талаас авах авлага 3.0 сая төгрөг байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 347.6 сая төгрөг байгаа нь ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас балансад шилжин ирсэн дахин үнэлсэн 78.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, шинээр худалдан авсан 82.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 223.4 сая төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгсэл, 28.1 сая төгрөгийн цахилгаан хэрэгслээр тус тус нэмэгдэж, 65.0 сая төгрөгийн элэгдлийг байгуулсантай холбоотой;
- Компанийн ТУЗ-ийн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор компанийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдаж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор 1,900.0 сая төгрөг хүртэлх шугамын зээл банкнаас авахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрч, жилийн эцэст Хаан банканд 1,280.0 сая төгрөгийн зээл, 11.5 мянган төгрөгийн зээлийн хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 3 байгууллагаас хөрөнгө, бичиг хэргийн материалын үнэд төлөөгүй 142.9 сая төгрөг, цалингийн өглөг 42.9 сая төгрөг, татварын өглөг 6.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
- Тайлант онд 3,354.2 сая төгрөгийн цэвэр борлуулалттай, 2.7 сая төгрөгийн бусад орлого, нийт 3,356.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 4,206.8 сая төгрөгийн зардал гаргаж, 849.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь хуримтлагдсан ашиг дансанд нөлөөлсөн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу хөрөнгө оруулалт болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

“Эрчист Монгол” ТӨХК-ийн 2025 оны төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ний өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан. Тайлант оны нийт орлогыг 4,861.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,458.8 сая төгрөгөөр, татварын дараах цэвэр ашгийг 362.2 сая төгрөг байхаар тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 401.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 3,356.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,206.8 сая төгрөгийн зардал гарган, 849.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,356.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,504.4 сая төгрөг буюу 30.9 хувиар дутуу бүрдсэн нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-иудын санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, менежментийн төлбөрийг төлөх боломжгүй болсноос шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 4,206.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 252.0 сая төгрөг буюу 5.7 хувиар дутуу зарцуулагдсан байна. Энэ нь хангамж, бараа материалын зардлыг 51.6 хувь, томилолтын зардлыг 77.6 хувь, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 67.0 хувь дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

#### **Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд 520.1 сая төгрөгийн 9 төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 439.9 сая төгрөгийн худалдан авалтыг хийж, 84.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Программ хангамж	46,474,500.00	37,333,128.00	9,141,372.00	80.3
2	Дотоод сүлжээ, интернет үйлчилгээ	18,040,000.00	12,878,073.00	5,161,927.00	71.4
3	Тавилга эд хогшил	98,841,200.00	86,990,000.00	11,851,200.00	88.0
4	Компьютер принтер	240,758,000.00	224,560,000.00	16,198,000.00	93.3
5	Тоног төхөөрөмж	62,253,930.00	55,700,000.00	6,553,930.00	89.5
6	Бичиг хэрэг	12,600,000.00	4,880,147.00	7,719,853.00	38.7
7	Тээвэр шатахуун	1,997,750.00	913,700.00	1,084,050.00	45.7
8	Аж ахуйн эд, зүйлс	19,600,000.00	3,877,000.00	15,723,000.00	19.8
9	Гэрээт цэвэрлэгээ үйлчилгээ	19,600,000.00	12,852,778.00	6,747,222.00	65.6
	<b>Нийт</b>	<b>520,165,380.00</b>	<b>439,984,826.00</b>	<b>80,180,554.00</b>	<b>84.6</b>

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэлээ. Үүнд:

**Бүтэц орон тоо:** Компанийн ТУЗ-ийн 2025 оны 03, 25 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн, орон тооны дээд хязгаарыг 70 байхаар тогтоосон байна. Гүйцэтгэлээр 2025 оны 12 дугаар сард ТУЗ-ийн 9 гишүүн, ажлын албаны 5 ажилтан, компанийн удирдах, гүйцэтгэх болон гэрээт 53 ажилтантай буую батлагдсан орон тооноос 12-оор дутуу ажиллаж, 9 хувиар бууруулаагүй байна.

**Унаа, хоолны хөнгөлөлт:** Компанийн ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ний өдрийн 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар унаа, хоолны хөнгөлөлтийг 515.3 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 280.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/11 дугаар тушаалаар унаа, хоолны хөнгөлөлтийг өдрийн 30,000.0 төгрөг байхаар тогтоосон байна.

**Гадаад томилолт:** Бүгд Найрамдах Казакстан улсад 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 07-ний өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн айлчлалын бүрэлдэхүүнд “Эрчист Монгол” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал багтаж, Монгол-Казакстан ажил хэргийн зөвлөлийн II хуралдаанд оролцсон байна. Тус хуралдаанаар “Самрук Казына” баялгийн сангийн төлөөлөлтэй уулзаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжуудын талаар санал солилцсон байна. Албан томилолтын зардалд 4.9 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд бусад зардлыг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас олгосон байна.

**Программ хангамж:** Компанийн дотоод үйл ажиллагаанд шаардлагатай “Dynamic” санхүүгийн программ, “Microsoft 365” оффисын хэрэглээний программыг нэвтрүүлж 28.6 сая төгрөгийг зарцуулсан байна. 2026 онд “Able” цаг бүртгэл, дотоод хяналт, удирдлагын программыг нэвтрүүлсэн байна.

**Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн:** Тайлант онд “Компанийн засаглал”, “Дотоод хяналт, эрсдэлийн удирдлага” сургалтыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хурлын танхимд зохион байгуулж, 50 ажилтан сургалтад хамрагдаж, 12.5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд сургалтад хамрагдсан ажиллагсад Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн өгөгдлийн санд бүртгэгдсэн байна.

**Хурал зөвлөгөөн:** Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04, 137 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, “Эрчист Монгол” ТӨХХК-ийн дүрэм, үйл ажиллагаа, стратегийг

танилцуулах, харьяа компаниудын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх зорилгоор Төрийн ордон болон Богд Тауэр-т 2 удаагийн зөвлөгөөн зохион байгуулж, харьяа компаниудын удирдлагын төлөөлөл болох 90 ажилтан, алба хаагчдыг хамруулан, 12.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Эрчист Монгол” ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит “Эрчист Монгол” ТӨХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Энэхүү тайланд аудит хийсэн байгууллагад хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитор С.Билгүтэй нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

“Эрчист Монгол” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 4,206.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 42.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани хангамж, бараа материалын зардал, ашиглалтын зардал, томилолт, зочны зардлыг хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 3 зөрчил илэрсэнд зөрчилд 3 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг шалгахад 28 төрлийн мэдээллийг байршуулахаас 23 мэдээллийг шилэн дансанд байршуулж, байгууллагын батлагдсан төсөв, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, худалдан авах

ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн мэдээлэх зөвлөмж өгсөн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Илрүүлэлт: Тайлант онд менежментийн гэрээ байгуулсан 28 байгууллагын 2024 оны орлого үр дүнгийн тайланг авч үзвэл 19 байгууллага нь 87,748.8 сая төгрөгийн цэвэр ашигтай, 9 байгууллага нь 21,197.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн үр дүнг харгалзан үзэлгүй нийтлэг хэмжээгээр менежментийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож, салбарын яамны эрх, үүрэгтэй давхацсан мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах төлбөртэй үйлчилгээ үзүүлж байгаа нь харьяа компаниудын менежментийн бодлогыг алдагдуулах, татварын шинжтэй өрийн дарамт үүсгэх, зардлыг нэмэгдүүлэх, байгууллагын санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Энэ нь УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 5.2.19-т "Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна", Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй", ЗГ-ын 2025 оны 4 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн дүрмийн 2.2-т "Компани нь харьяа компаниудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоох, бизнесийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөө, уялдаа зохицуулалтаар хангах болон санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр менежментийн үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах үндсэн үйл ажиллагаа явуулна" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Харьяа төрийн өмчит компанийн санхүүгийн үр дүнг харгалзан менежментийн төлбөр тогтоох аргачлалыг боловсруулж, байгууллагад өрийн дарамт үүсгэхгүй байхаар мэргэжлийн ажил үйлчилгээг үе шаттай гүйцэтгэх зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт: Компанийн ТУЗ-ийн 2025 оны 21 дүгээр тогтоолоор 1,900.0 сая төгрөг хүртэлх шугамын зээл авч үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн. Мөн 44 дүгээр тогтоолоор шугамын зээлийн гэрээний хугацааг сунгаж, 5060173840 тоот дансны орлогыг үргэлжлүүлэн барьцаалуулахыг зөвшөөрсөн байна. Жилийн эцэст 1,280,000.0 мянган төгрөгийн шугамын зээлийн үлдэгдэлтэй, 11,477.6 мянган төгрөгийн хүүгийн өглөгтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", ТУЗ-ийн 2025 оны 21 дүгээр тогтоолын 3-т "Энэ тогтоолын дагуу авах зээлтэй холбоотойгоор 2025 оны санхүүгийн жилийн эцэст үлдэгдэлгүй, зээлтэй холбоотой аливаа хуримтлагдсан өр төлбөр үүсгэхгүй байж ажиллахыг Гүйцэтгэл захирал-д үүрэг болгосугай" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон төсвийг зохистой

удирдлагыг хэрэгжүүлээгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн үр дүнг харгалзан үзэлгүй нийтлэг хэмжээгээр менежментийн төлбөрийг тогтоосон нь Төсвийн тухай хууль, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолтой нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Эрчист Монгол” ТӨХХК-ийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Аудит хийгдээгүй шинээр байгуулагдсан байгууллага юм.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай дараах асуудал байна гэж үзлээ. Үүнд:

- Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан болон ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг үнэлж, дүгнэсэн байдал;
- “Эрчист Монгол” ТӨХХК нь дансны орлогыг барьцаалан үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны банкнаас шугамын зээл авсан бөгөөд зээлийн эргэн төлөлтийн эрсдэл, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс орлогын төлөвлөлт, бүтэц, мөнгөн урсгалын удирдлагын бодлого, хэрэгжилтийг нарийвчлан шалгах.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 1,810.3 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд, 317.9 сая төгрөгийн сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1,492.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,810.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,768.2 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### **5.1 Албан шаардлага**

5.1.1 Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авсан 143.0 сая төгрөг, цалингийн өглөг 42.9 сая төгрөг, татварын өр 6.4 сая төгрөг, санхүүгийн тайланд 192.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн зохистой удирдлагыг хангаж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2 Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн дотоод журмыг баримтлалгүй 12 дугаар сард 19 ажилтанд 47.4 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгоходоо 4 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх илүү цагаар ажилласан цагийн хүснэгтийг үндэслэж нөхөн олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-т "Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно", 91.2.4-т "урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх", Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/26 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.6-т "Санхүү, нягтлан бодох бүртгэлийн газар нь Захиргаа, хүний нөөцийн хэлтсээс ирүүлсэн ажлын цагийн бүртгэлд үндэслэн цалинг бодно", 9 дүгээр зүйлийн 9.1-т "Ажилтны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшууллын хэмжээг холбогдох журамд заасны дагуу Гүйцэтгэх захирал тогтоож, олгоно", 9.6-т "Ажилтны цалинг сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд 2 удаа олгох бөгөөд тухайн өдөр нь нийтээр амрах баярын өдөр болон долоо хоногийн амралтын өдөр байвал өмнөх ажлын өдөр нь олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн дотоод хэм хэмжээгээр баталсан зохицуулалтыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.1.3 Компанийн ТУЗ-ийн 2025 оны 03, 25 дугаар тогтоолоор компанийн орон тооны дээд хязгаарыг 70 хүнтэй тогтоож, 12 дугаар сард гүйцэтгэлээр 58 хүний орон тоотой ажилласан. Байгууллагын хэмжээнд картлагдаагүй 87 ширхэг 25.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 34 ширхэг 53.0 сая төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг ашиглалтад тавьж олгоогүй, хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалтыг зохион байгуулаагүйгээс шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-т "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгцээ шаардлагад үндэслэн үр ашигтай төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.2.1 Авлагын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн дүрэм, ТУЗ-ийн 2025 оны 16 дугаар тогтоолоор менежментийн төлбөрийн хувь хэмжээг тухайн компанийн борлуулалтын орлогын 1 хувиар тогтоосон байна. Тайлант онд 2 байгууллага нь менежментийн төлбөрийг төлөх боломжгүй байгааг албан бичгээр ирүүлснээс ДЦС IV ТӨХК-аас авах 1,112.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ дүгнэх эсэхийг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэх, дотоод хяналтыг сайжруулах.

#### **5.2.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Компанийн балансад бүртгэлтэй 3 төрлийн 388 ширхэг 358.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг жилийн эцэст тоолсон тооллогын комиссын зарим гишүүд тайлан, дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Хагас жил, жилийн эцсийн тооллогыг чанартай гүйцэтгэж, үнэн зөв, бодитой тоологдсон эсэхийг комиссын гишүүд эд хариуцагчдад бүрэн танилцуулан, баталгаажуулж байх.

#### **5.2.3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын 1 ажилтанд 10 дугаар сард 8 өдрийн цалинтай чөлөөг тушаал шийдвэргүйгээр олгож, 1.9 сая төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-т "Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно", 100.2-т "Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна", Гүйцэтгэх захирлын 2025 оны А/26 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.3.7-т "Ажилтанд ажлын 5 (тав)-аас дээш өдрийн цалинтай чөлөө, 10 (арав)-аас дээш өдрийн цалингүй чөлөөг гүйцэтгэх захирлын тушаалаар олгоно" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын зүйл заалтыг мөрдөж, цалин хөлсийг олгож байх.

#### **5.2.4 Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан 46-н компьютероос 14, 22 нотебүүкээс 7-г огт ашиглагдаагүй, шинээрээ байгаа хөрөнгөнд нийт 3.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна. Мөн оны сүүлд авсан тавилга, эд хогшлоос угсраагүй шинээрээ байгаа бичгийн шүүгээ 7, хувцасны шүүгээ 3, ширээ 11, сандал 16 ширхэг хөрөнгө байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн программ хангамжийг сайжруулж, ашиглалтад тавьж олгосон үеэс эхлэн элэгдлийн зардлыг бодуулах тохиргоог хийлгэж, зардлыг бодитой тайлагнах.

## **5.2.5 Бараа материалын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан БМ-6 маягт болох шаардах хуудаст удирдлага, ерөнхий нягтлан бодогч цохолт хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу бичиг хэргийн материал 4.1 сая төгрөг, аж ахуйн материал 9.9 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 0.8 сая төгрөг, шатах тослох материал 0.9 сая төгрөг, нийт 15.7 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-т "Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтад нэгжийн удирдлага цохолт хийж, нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, зохион байгуулалтыг хангаж, ажил гүйлгээг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авсан 143.0 сая төгрөг, цалингийн өглөг 42.9 сая төгрөг, татварын өр 6.4 сая төгрөг, санхүүгийн тайланд 192.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүй байна.	1	192.3			1	192.3		
Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн дотоод журмыг баримтлалгүй 12 дугаар сард 19 ажилтанд 47.4 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгохдоо 4 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх илүү цагаар ажилласан цагийн хүснэгтийг үндэслэж нөхөн олгосон байна.	1	47.4			1	47.4		
Компанийн ТУЗ-ийн 2025 оны 03, 25 дугаар тогтоолоор компанийн орон тооны дээд хязгаарыг 70 хүнтэй тогтоож, 12 дугаар сард гүйцэтгэлээр 58 хүний орон тоотой ажилласан. Байгууллагын хэмжээнд картлагдаагүй 87 ширхэг 25.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 34 ширхэг 53.0 сая төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг ашиглалтад тавьж олгоогүй, хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалтыг зохион байгуулаагүйгээс шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн байна.	1	78.2			1	78.2		
Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн дүрэм, ТУЗ-ийн 2025 оны 16 дугаар тогтоолоор менежментийн төлбөрийн хувь хэмжээг тухайн компанийн борлуулалтын орлогын 1 хувиар тогтоосон байна. Тайлант онд 2 байгууллага нь менежментийн төлбөрийг төлөх боломжгүй байгааг албан бичгээр ирүүлснээс ДЦС IV ТӨХК-аас авах 1,112.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ дүгнэх эсэхийг эцэслэн шийдвэрлээгүй байна.	1	1,112.5					1	1,112.5
Компанийн балансад бүртгэлтэй 3 төрлийн 388 ширхэг 358.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг жилийн эцэст тоолсон тооллогын комиссын зарим гишүүд тайлан, дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.	1	358.9					1	358.9
Байгууллагын 1 ажилтанд 10 дугаар сард 8 өдрийн цалинтай чөлөөг тушаал шийдвэргүйгээр олгож, 1.9 төгрөгийн цалинг олгосон байна.	1	1.9					1	1.9
Тайлант онд худалдан авсан 46-н компьютероос 14, 22 нотебүүкээс 7-г огт ашиглагдаагүй, шинээрээ байгаа хөрөнгөнд нийт 3.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна. Мөн оны сүүлд авсан тавилга, эд хогшлоос угсраагүй шинээрээ	1	3.4					1	3.4

байгаа бичгийн шүүгээ 7, хувцасны шүүгээ 3, ширээ 11, сандал 16 ширхэг хөрөнгө байна.								
Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан БМ-6 маягт болох шаардах хуудаст удирдлага, ерөнхий нягтлан бодогч цохолт хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу бичиг хэргийн материал 4.1 сая төгрөг, аж ахуйн материал 9.9 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 0.8 сая төгрөг, шатах тослох материал 0.9 сая төгрөг, нийт 15.7 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.	1	15.7					1	15.7
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>1,810.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>317.9</b>	<b>5</b>	<b>1,492.4</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим системд нийт 28 төрлийн мэдээллийг байршуулахаас 23 мэдээллийг шилэн дансанд байршуулж, байгууллагын батлагдсан төсөв, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг 4 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-					1	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант онд менежментийн гэрээ байгуулсан 28 байгууллагын 2024 оны орлого үр дүнгийн тайланг авч үзвэл 19 байгууллага нь 87,748.8 сая төгрөгийн цэвэр ашигтай, 9 байгууллага нь 21,197.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн үр дүнг харгалзан үзэлгүй нийтлэг хэмжээгээр менежментийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож, салбарын яамны эрх, үүрэгтэй давхацсан мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах төлбөртэй үйлчилгээ үзүүлж байгаа нь харьяа компаниудын менежментийн бодлогыг алдагдуулах, татварын шинжтэй өрийн дарамт үүсгэх, зардлыг нэмэгдүүлэх, байгууллагын санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.	1	-					1	-
Компанийн ТУЗ-ийн 2025 оны 21 дүгээр тогтоолоор 1,900.0 сая төгрөг хүртэлх шугамын зээл авч үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн. Мөн 44 дүгээр тогтоолоор шугамын зээлийн гэрээний хугацааг сунгаж, 5060173840 тоот дансны орлогыг үргэлжлүүлэн барьцаалуулахыг зөвшөөрсөн байна. Жилийн эцэст 1,280,000.0 мянган төгрөгийн шугамын зээлийн үлдэгдэлтэй, 11,477.6 мянган төгрөгийн хүүгийн өглөгтэй тайлагнасан байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>					<b>3</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 636/АД171328

Улаанбаатар хот

САГ-2026/70/НА-СТА-ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчист Монгол ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03, 25 дугаар тогтоолоор компанийн орон тооны дээд хязгаарыг 70 хүнтэй тогтоож, 12 дугаар сард гүйцэтгэлээр 58 хүний орон тоотой ажилласан. Байгууллагын хэмжээнд картлагдаагүй 87 ширхэг 25,236,363.64 (хорин таван сая хоёр зуун гучин зургаан мянга гурван зуун жаран гурван төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн тавилга эд хогшил, 34 ширхэг 52,970,627.27 (тавин хоёр сая есөн зуун далан мянга зургаан зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг ашиглалтад тавьж олгоогүй, хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалтыг зохион байгуулаагүйгээс шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгцээ шаардлагад үндэслэн үр ашигтай төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчист Монгол ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Амартүвшин), ерөнхий нягтлан бодогч (Х.Цэрэннадмид) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-18.Docx

1526180753



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 637/А0171328

Улаанбаатар хот

САГ - 2026 /70/КА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчист Монгол ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн дотоод журмыг баримтлалгүй 12 дугаар сард 19 ажилтанд 47,421,818.14 (дөчин долоон сая дөрвөн зуун хорин нэгэн мянга найман зуун арван найман төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн илүү цагийн хөлсийг олгохдоо 4 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх илүү цагаар ажилласан цагийн хүснэгтийг үндэслэж нөхөн олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д "Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно", 91.2.4-т "урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх", Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/26 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.6-т "Санхүү, нягтлан бодох бүртгэлийн газар нь Захиргаа, хүний нөөцийн хэлтсээс ирүүлсэн ажлын цагийн бүртгэлд үндэслэн цалинг бодно", 9 дүгээр зүйлийн 9.1-д "Ажилтны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшууллын хэмжээг холбогдох журамд заасны дагуу Гүйцэтгэх захирал тогтоож, олгоно", 9.6-д "Ажилтны цалинг сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд 2 удаа олгох бөгөөд тухайн өдөр нь нийтээр амрах баярын өдөр болон долоо хоногийн амралтын өдөр байвал өмнөх ажлын өдөр нь олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн дотоод хэм хэмжээгээр баталсан зохицуулалтыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчист Монгол ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Амартүвшин), ерөнхий нягтлан бодогч (Х.Цэрэннадмид) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-18.Docx

1526180751



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 638/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/70/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчист Монгол ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авсан 142,952,080.00 (нэг зуун дөчин хоёр сая есөн зуун тавин хоёр мянга наян төгрөг) төгрөг, цалингийн өглөг 42,921,164.59 (дөчин хоёр сая есөн зуун хорин нэгэн мянга нэг зуун жаран дөрвөн төгрөг тавин есөн мөнгө) төгрөг, татварын өр 6,413,944.32 (зургаан сая дөрвөн зуун арван гурван мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг гучин хоёр мөнгө) төгрөг, санхүүгийн тайланд 192,287,188.91 (нэг зуун ерэн хоёр сая хоёр зуун наян долоон мянга нэг зуун наян найман төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн зохистой удирдлагыг хангаж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчист Монгол ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Амартүвшин), ерөнхий нягтлан бодогч (Х.Цэрэннадмид) нарт даалгах.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ